



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### VIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын VIII хурал 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 12:00 цагаас Төрийн ордонд Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 96 хувийн ирцтэйгээр хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ

1. Коронавируст халдвар (Covid-19)-ын өнөөгийн гадаад, дотоод нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;

2. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа монголчуудын нөхцөл байдал, Монгол Улс руу зорчих хөдөлгөөнийг хязгаарлах боломж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Д.Даваасүрэн;

3. Улс хоорондын зорчигч тээвэр (агаарын болон төмөр зам)-ийн хөдөлгөөнийг зохицуулах замаар коронавируст халдварын голомт бүхий бүс нутгаас ирэх иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;

4. Улс, хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдөр нээхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав;

5. Нүүрс, газрын тосны экспортыг эхлүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар нарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,  
Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Н.Цэрэнбат,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг,  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Л.Баатарбилэг,  
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх талаар авч буй арга хэмжээний хүрээнд тусгаарлах байрыг шаардлагатай тохиолдолд дараах эрэмбийн дагуу бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажиллуулах:

- 1.1.1. төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал,
- 1.1.2. төрийн болон хувийн хэвшлийн амралтын газар,
- 1.1.3. их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр,
- 1.1.4. зочид буудал,
- 1.1.5. спорт цогцолбор, заал,
- 1.1.6. сургуулийн дотуур байр,
- 1.1.7. цэцэрлэг;

1.2. Нэн тэргүүний ээлжинд ашиглах тусгаарлах байрыг 2020 оны 3 дугаар сарын 10-ний өдрийн дотор бэлэн болгох.

Хоёр. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,  
Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт:

2.1. Тусгаарлах /ажиглах/ үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл мэндийн даатгалын сан, халамжийн сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн шуурхай шийдвэрлэх;

2.2. Нэг иргэнийг тусгаарлахад шаардагдах зардлын тооцоог судалж, 3 дугаар сарын 4-ний өдрийн дотор танилцуулах;

Гурав. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чинбат нарт:

3.1. Гэрийн дэглэмээр тусгаарлагдан ажиглалтанд байгаа иргэний байршлыг GPS төхөөрөмжөөр тогтоож, хянах боломжийг судалж танилцуулах;

Дөрөв. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын  
генерал С.Баатаржав,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга,  
хошууч генерал Т.Бадрал,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн  
Н.Цагаанхүү,  
Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Хот хоорондын зорчих хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдөр нээхтэй холбогдуулан 3 дугаар сарын 5-ны өдрийг дуустал үндсэн 7 шалган нэвтрүүлэх цэгт нэмэлтээр онцгой байдал, мэргэжлийн хяналт, эрүүл мэндийн байгууллагаас хүн хүч нэмэгдүүлж ажиллуулах;

4.2. Тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарт халдваргүйжүүлэлт, зорчигчдийн эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой заавар, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;

4.3. Хилийн боомтууд дахь халдварт вирусын сэжигтэй иргэдийг тусгаарлах үйл ажиллагааны явцад салбар хоорондын уялдааг хангаж ажиллах;

Тав. Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
Б.Энх-Амгалан,  
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар. :

5.1. БНСУ, Япон Улсаас эх орондоо зорчих Монгол Улсын иргэдийг захиалгат нислэгээр татан авчрах тохиолдолд коронавируст халдварын шинжилгээнд заавал хамруулах;

5.2. Улс, хот хооронд төмөр замын тээврээр зорчиж буй иргэдийн суудлын тоог хэтрүүлэхгүй байлгахад хяналт тавих;

Зургаа. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
Д.Сумьяабазар,

Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан, Хил  
хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,  
бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн  
Н.Цагаанхүү,

Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,  
Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт:

5.1. Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэх журмыг шуурхай боловсруулж мөрдөж ажиллах;

5. Дорноговь аймгийн "Замын-Үүд-Эрээн" авто замын боомтоор чингэлэгээр нүүрс тээвэрлэх бэлтгэл ажилтай танилцаж, санал дүгнэлт гарган, тээвэрлэлтийн зохион байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН  
ДЭД ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

  
Г.АРИУНБУЯН